



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ

2025 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/10

Дадал сум

Байгууллагын дотоод хяналт шалгалт
зохион байгуулах ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.11 Боловсролын Ерөнхий хуулийн 33.3.1, Төсвийн тухай хуулийн 16.5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын “Дотоод хяналт шалгалт”-ыг зохион байгуулах ажлын хэсгийг дор дурьдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Хэсгийн ахлагч:	О.Урансайхан	(Аргазүйч)
Гишүүд:	Б.Амаржаргал	(Багшийн туслах)
	О.Анхцэцэг	(Ахлах тогооч)
	Б.Алигэрмаа	(Угаагч)
	Х.Отгонжаргал	(Жижүүр)

2. Байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх “Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам”-ыг багш ажилтан бүрийн хүлээсэн үүргийн хэрэгжилт, хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, хөдөлмөрийн дотоод журмын биелэлт, өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, шилэн дансны хэрэгжилт зэргийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд тусган боловсруулж батлуулан мөрдөж ажиллахыг ажлын хэсэг бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/06 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ЭРХЛЭГЧ Н.ОДГАРАВ

